



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8,25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.5, дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх” мон-3787/3788 төслийн хүрээнд бий болсон, нийт 9,338,780,704.85 (есөн тэрбум гурван зуун гучин найман сая долоон зуун наян мянга долоон зуун дөрвөн төгрөг наян таван мөнгө) төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хэнтий, Хөвсгөл аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Билгээ, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Бэхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Зээлийн хөрөнгөөр ашиглалтад оруулсан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.2.Үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших эрхийг холбогдох орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133000743
11-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны дугаар сарын ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭР “ТОГТВОРТОЙ АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ” МОН-3787/3788 ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН ХЭНТИЙ,
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хариуцах байгууллага	Өмчийн нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хэнтий аймгийн орон нутгийн өмчийн газар (АЗДТГ)	Дадал сумын хатуу хог хаягдлын байгууламж	1	1,874,611,454.51	1,874,611,454.51
2		Юниверсал трактор	1	143,000,000.00	143,000,000.00
3		Өөрөө буулгагч машин	1	163,000,000.00	163,000,000.00
4		Бохир ус соруулах машин 5 тн	1	85,500,000.00	85,500,000.00
5		Хог пресслэгч	1	19,937,155.00	19,937,155.00
6		Дадал сумын автопүү	1	133,328,600.00	133,328,600.00
Дүн			6	2,419,377,209.51	2,419,377,209.51
1	Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газар (АЗДТГ)	Хатгал тосгоны хатуу хог хаягдлын байгууламж	1	2,600,830,241.54	2,600,830,241.54
2		Ханх сумын хатуу хог хаягдлын байгууламж	1	1,243,661,647.18	1,243,661,647.18
3		Хатгал тосгоны бохир ус цэвэрлэх байгууламж	1	1,137,412,502.63	1,137,412,502.63
4		Ханх сумын бохир ус цэвэрлэх байгууламж	1	770,341,903.99	770,341,903.99
5		Хатгал, Ханх сумын автопүү	2	133,328,600.00	266,657,200.00
6		Юниверсал трактор	1	143,000,000.00	143,000,000.00
7		Юниверсал трактор	1	143,000,000.00	143,000,000.00
8		Бохир ус соруулах машин 10тн	1	185,000,000.00	185,000,000.00
9		Бохир ус соруулах машин 5 тн	1	85,500,000.00	85,500,000.00
10		Өөрөө буулгагч машин	1	163,000,000.00	163,000,000.00
11		Өөрөө буулгагч машин	1	163,000,000.00	163,000,000.00
12		Хатгал тосгоны жанхайн давааны хяналтын камер	1	18,000,000.00	18,000,000.00
Нийт дүн			13	6,786,074,895.34	6,919,403,495.34
			19	9,205,452,104.85	9,338,780,704.85
					(Есөн тэрбум гурван зуун гучин найман сая долоон зуун наян мянга долоон зуун дөрөв төгрөг наян таван мөнгө)